БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Булган сумын нэгдүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021/16/-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган<br>2021 он | Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер:<br>Утас: 260815 Цахим хаяг:<br>Аудитор:<br>Утас: Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт............................................**Error! Bookmark not defined.**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан............................................5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............................................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............................................5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан............................................6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............................................11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............................................11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ............................................10

3. Аудитын тайлан............................................14

3.1. Ерөнхий зүйл............................................14

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ............................................14

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ............................................14

3.4. Материаллаг байдал ............................................14

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ............................................15

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ............................................16

3.7. Шилэн дансны мэдээлэл............................................16

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................17

3.9. Аудитын илрүүлэлт............................................17

Залруулсан алдаа............................................17

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ............................................17

Аудитын зөвлөмж............................................17

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ............................................18

4. Менежментийн захидал............................................18

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ............................................20

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.23 № 59

танай ____________-ны №______________т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ГЭРЭЛТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

006020127

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **139,790,358.98** | **106,418,038.00** |
| **33** | **АВЛАГА** | - | 30,172.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 30,172.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 136,976,158.98 | 103,573,666.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,988,366.00 | 9,155,566.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,916,566.00 | 9,071,566.00 |
| 35130 | Эм боох материал | 71,800.00 | 84,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 120,992,792.98 | 89,138,100.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 351,000.00 | 620,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 91,168,919.98 | 73,654,886.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 594,000.00 | 726,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 967,000.00 | 1,254,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 18,990,839.00 | 4,874,580.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,921,034.00 | 8,008,634.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | 6,995,000.00 | 5,280,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 2,814,200.00 | 2,814,200.00 |
| 36600 | Бусад нөөц | 2,814,200.00 | 2,814,200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,922,575,438.25** | **5,289,795,214.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,922,575,438.25 | 5,289,795,214.59 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,444,480,328.69 | 4,810,637,298.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,184,375,017.00 | 4,624,013,517.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,994,745,433.78) | (241,678,612.05) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 287,873,550.61 | 301,949,208.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (216,292,564.95) | (76,514,927.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 279,852,154.54 | 266,867,230.45 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (122,124,770.32) | (87,703,353.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 42,590,592.64 | 27,019,681.41 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (37,700,038.05) | (17,621,137.35) |
| 39217 | Ном | 20,651,821.00 | 14,305,690.67 |

| | | | |
|---|---|---|---|
| **393** | **Биет бус хөрөнгө** | 478,095,109.56 | 479,157,916.30 |
| 39301 | Програм хангамж | 1,804,860.00 | 3,154,860.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,119,750.44) | (1,406,943.70) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 477,410,000.00 | 477,410,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,062,365,797.23** | **5,396,213,252.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,062,365,797.23** | **5,396,213,252.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,062,365,797.23 | 5,396,213,252.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,256,550,162.42 | 1,256,550,162.42 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,256,550,162.42 | 1,256,550,162.42 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,423,936,685.71 | 2,757,784,141.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,423,936,685.71 | 3,423,936,685.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (666,152,544.64) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,381,878,949.10 | 1,381,878,949.10 |
| 51600 | Нөөцийн сан | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,062,365,797.23** | **5,396,213,252.59** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,092,924,030.00** | **2,473,988,603.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **32,061,030.00** | **226,096,503.33** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32,061,030.00 | 226,096,503.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 26,022,230.00 | 226,096,503.33 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,108,950.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,913,280.00 | 226,096,503.33 |
| 120009 | Бусад орлого | 6,038,800.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,060,863,000.00** | **2,247,892,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,691,685,200.00 | 1,936,324,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,691,685,200.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,936,324,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 369,177,800.00 | 310,967,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 369,177,800.00 | 310,967,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,242,268,516.78** | **2,480,439,098.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,242,268,516.78** | **2,480,439,098.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,153,606,540.34 | 2,310,468,046.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,258,592,356.00 | 1,486,325,677.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,031,835,815.00 | 958,007,214.00 |
| 210102 | Нэмэгдэл | 106,397,000.00 | 312,751,882.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 54,264,142.00 |
| 210104 | Урамшуулал | 120,359,541.00 | 161,302,439.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 170,207,354.56 | 187,095,258.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 115,741,000.56 | 126,858,609.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,616,588.00 | 15,112,610.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,893,271.00 | 12,083,588.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,723,317.00 | 3,003,559.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,233,178.00 | 30,036,891.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 358,913,016.00 | 308,162,745.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,687,560.00 | 11,330,914.00 |
| 210302 | Түлш, халаалт | 313,099,104.00 | 278,558,187.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,126,352.00 | 18,273,644.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,896,617.00 | 14,890,440.68 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,689,050.00 | 1,931,443.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,603,300.00 | 1,644,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 881,567.00 | 791,497.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 318,200.00 | 142,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 125,000.00 | 642,990.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,279,500.00 | 7,581,017.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 2,156,893.68 |
| **2105** | **Нормативт зардал** | 100,543,782.00 | 52,571,014.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 400,000.00 | 1,495,105.00 |
| 210502 | Хоол, хүнс | 89,355,439.00 | 44,284,359.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,788,343.00 | 6,791,550.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,256,440.00 | 7,185,925.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 10,256,440.00 | 7,185,925.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 401,500.00 | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 401,500.00 | 80,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,224,800.00 | 7,166,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,128,800.00 | 6,842,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 96,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 238,570,674.78 | 246,990,385.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,384,450.00 | 3,360,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,080,945.00 | 2,409,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 234,105,279.78 | 241,220,485.72 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 88,661,976.44 | 169,971,052.10 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 58,932,000.00 | 34,550,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,155,000.00 | 32,175,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,777,000.00 | 2,375,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29,729,976.44 | 135,420,152.10 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,729,976.44 | 135,420,152.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(149,344,486.78)** | **(6,450,495.07)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | 8,660,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | 8,660,000.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 5,997,656.88 | 668,362,049.57 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,997,656.88 | 668,362,049.57 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (5,997,656.88) | (659,702,049.57) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(155,342,143.66)** | **(666,152,544.64)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,071,010,750.00** | **2,262,625,170.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,147,750.00** | **14,733,070.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,147,750.00 | 14,733,070.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,108,950.00 | 3,110,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,108,950.00 | 3,110,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 6,038,800.00 | 11,623,070.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,060,863,000.00** | **2,247,892,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,691,685,200.00 | 1,936,324,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,691,685,200.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,936,324,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 600,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 369,177,800.00 | 310,967,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 369,177,800.00 | 310,967,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,011,454,035.00** | **2,236,523,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,011,454,035.00** | **2,236,523,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,922,792,058.56** | **2,066,552,847.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,267,988,883.06 | 1,471,341,816.00 |
| 210101 | Үндсэн цалин | 870,621,035.06 | 940,794,538.00 |
| 210102 | Нэмэгдэл | 210,905,595.00 | 312,803,683.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 54,264,142.00 |
| 210104 | Урамшуулал | 186,462,253.00 | 163,479,453.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 160,545,047.50 | 202,109,291.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,248,647.50 | 141,872,642.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,824,100.00 | 15,112,610.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,259,300.00 | 12,083,588.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,564,800.00 | 3,003,559.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,648,200.00 | 30,036,891.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 360,687,016.00 | 308,888,745.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,687,560.00 | 11,330,914.00 |
| 210302 | Түлш, халаалт | 314,873,104.00 | 279,284,187.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,126,352.00 | 18,273,644.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,592,267.00 | 12,635,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 827,400.00 | 850,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,895,300.00 | 1,050,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 985,067.00 | 791,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 720,500.00 | 597,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 210,800.00 | 3,881,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,953,200.00 | 5,464,780.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 100,465,740.00 | 50,785,270.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 571,200.00 | 731,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 94,294,710.00 | 41,791,170.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,599,830.00 | 8,262,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,250,300.00 | 1,700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,250,300.00 | 1,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 401,500.00 | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 401,500.00 | 80,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,682,500.00 | 8,174,175.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,586,500.00 | 7,850,175.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 96,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,178,805.00 | 10,838,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,393,710.00 | 3,710,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,785,095.00 | 7,128,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **88,661,976.44** | **169,971,052.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 58,932,000.00 | 34,550,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,155,000.00 | 32,175,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,777,000.00 | 2,375,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29,729,976.44 | 135,420,152.10 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,729,976.44 | 135,420,152.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **59,556,715.00** | **26,101,270.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **59,556,715.00** | **26,101,270.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **59,556,715.00** | **26,101,270.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 59,556,715.00 | 26,101,270.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 59,556,715.00 | 26,021,270.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 80,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(59,556,715.00)** | **(26,101,270.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,256,550,162.42 | 1,381,878,949.10 | 3,579,278,829.37 | 6,217,707,940.89 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,579,278,829.37** | 6,217,707,940.89 |
| C04 | Тайлант үеийн үр дүн | - | - | (155,342,143.66) | (155,342,143.66) |
| C05 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,423,936,685.71** | 6,062,365,797.23 |
| C06 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,423,936,685.71** | 6,062,365,797.23 |
| C07 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C08 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,423,936,685.71** | 6,062,365,797.23 |
| D05 | Тайлант үеийн үр дүн | - | - | (666,152,544.64) | (666,152,544.64) |
| D06 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **2,757,784,141.07** | 5,396,213,252.59 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2260222000.00 | 2123495017.90 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2260222000.00 | 2097393747.90 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2209313000.00 | 2062842847.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1510975600.00 | 1471341816.00 |
| 210101 | Үндсэн цалин | 969400000.00 | 940794538.00 |
| 210102 | Нэмэгдэл | 320019900.00 | 312803683.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 60000000.00 | 54264142.00 |
| 210104 | Урамшуулал | 161555700.00 | 163479453.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 202728900.00 | 202109291.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 141993800.00 | 141872642.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15183800.00 | 15112610.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12147000.00 | 12083588.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3036800.00 | 3003559.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30367500.00 | 30036891.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 336869300.00 | 308888745.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16300000.00 | 11330914.00 |
| 210302 | Түлш, халаалт | 301064100.00 | 279284187.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19505200.00 | 18273644.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36370800.00 | 12635050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 850000.00 | 850000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1050000.00 | 1050000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 994,000.00 | 791,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 897,100.00 | 597,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,773,000.00 | 3,881,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,806,700.00 | 5,464,780.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 102,598,200.00 | 50,785,270.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 731,200.00 | 731,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,604,100.00 | 41,791,170.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,262,900.00 | 8,262,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 901,500.00 | 80,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 901,500.00 | 80,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,767,200.00 | 8,174,175.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,093,200.00 | 7,850,175.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,101,500.00 | 7,128,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 400,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,701,500.00 | 7,128,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50,909,000.00 | 34,550,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,909,000.00 | 34,550,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,309,000.00 | 32,175,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,600,000.00 | 2,375,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **26,101,270.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 26,101,270.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 26,021,270.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 80,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,276,227,500.00 | 2,247,292,100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,936,324,300.00 | 1,936,324,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,936,324,300.00 | 1,936,324,300.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 339,903,200.00 | 310,967,800.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 339,903,200.00 | 310,967,800.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 118.00 | 118.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 87.00 | 87.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.00 | 30.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,512.00 | - |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,394.00 | - |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,394.00 | |
| 630002 | Хувийн ЕБС | | |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 118.00 | - |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 81.00 | |
| 631002 | Хувийн өмчит СӨБ байгууллага | 37.00 | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Булган сумын нэгдүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном аудитыг гүйцэтгэн хэрэгжүүлэв.

Булган сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны 04 өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын нэгдүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллаагаа

Үндсэн зорилго: Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Сургалт хүмүүжлийн ажлыг цогцоор төлөвлөж, хичээл ба хичээлээс гадуурх ажлаар хүүхдийг хөгжүүлнэ.
- Багш бүр мэдлэг чадвар, заах аргаа байнга дээшлүүлж ажлын байранд суралцан “Чадварлаг бүтээлч багш болно” болно.
- Математик, англи хэл, монгол хэл сэтгэх чадварын хичээлүүдээр сурагчдыг түлхүү хөгжүүлнэ.
- Хүүхдэд ээлтэй, таатай сургалтын орчныг бүрдүүлнэ.
- Эцэг эх, багш сурагчийн хамтын үйл ажиллагааг үр бүтээлтэй ажил хэрэгч болгоно.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын нэгдүгээр сургууль нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны  жилийн эцсийн тайлангийн үр дүнгийн тайлангийн 1274671.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 25493.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын нэгдүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 666152.5 мянган төгрөгөөр буюу .... хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 0 | 30.2 | 30.2 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 136976.2 | 103573.7 | -33402.5 |
| Үндсэн хөрөнгө | 5922575.4 | 5289795.2 | -632780.2 |
| **Нийт хөрөнгө** | 6062365.8 | 5396213.3 | -666152.5 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 6062365.8 | 5396213.3 | -666152.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 6062365.8 | 5396213.3 | -666152.5 |

Авлага дансны үлдэгдэл 30.2 мянган төгрөг нь тайлант оны ХХОАТ-ыг илүү шилжүүлснээс авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 103573.7 мянган төгрөг болж 33402.5 мянган төгрөгөөр буурсан нь 2156.9 мянган төгрөгийн материал акталсан, 17339.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, хорио цээртэй холбоотой үйл ажиллагааг явуулаагүйгээс бараа материалын худалдан авалт багасаж эхний үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5289795.2 мянган төгрөг болж 632780.2 мянган төгрөгөөр буурсан нь сургуулийн хуучин барилга болон бусад үндсэн хөрөнгийн 2617580.4 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 26101.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 87910.2 мянган төгрөгөөр хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө сургуулийн хуучин барилга болон бусад үндсэн хөрөнгийн 2617580.4 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 1350.0 мянган төгрөг өссөн нь санхүүгийн программ орлогод авсан байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5396213.3 мянган төгрөг болж 666152.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээ болон, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Булган сумын нэгдүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 225538.8 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлэг 244639.1 мянган төгрөгийн санхүүжилт байна. Энэ нь цалингийн зардал 227733.3 мянган төгрөгөөс өссөн нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдлээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 238170.6 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал 227733.3 мянган төгрөгөөс өссөн нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2224760.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2224760.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12187.4 мянган төгрөгөөр бууруулж 2212572.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2212572.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1936324.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 339903.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1936324.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 310967.8 нийт 2247292.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2111871.9 мянган төгрөгийг зарцуулж 135420.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2111871.9 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь цалин хөлс 39633.8, байр ашиглалт 27980.6, хангамжийн бараа материал 23735.8, норматив зардал 51812.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 600.0 мянган төгрөг орлогыг бүрдүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, аудитаар өгсөн 12900.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 900.0 | 1 | 900.0 | | | |
| Албан шаардлага | 1 | 12000.0 | 1 | 12000.0 | | | |
| Зөвлөмж | | | | | | | |
| Нийт дүн | 2 | 12900.0 | 2 | 12900.0 | | | |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71006.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11705.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 14983.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 44317.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 26688.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 11705.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 14983.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 14983.9 мянган төгрөгийг цалингийн зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгсөн.

2. Хорио цээр тогтоосонтой холбоотой байгууллагын үйл ажиллаагааг танхимаар явуулахгүй, түр хугацаагаар зогсоосон байх хугацаанд багш ажилчдад хоолны нэмэгдэлд 11705.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" байгууллагын дотоод журмын 10.2.10-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 44317.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд компьютер техник хэрэгслийн ашиглах жилийг буруу тооцсон байна. Тухайлбал: 20 жилээр 11 нэр төрлийн 15558.3 мянган төгрөгийн хөрөнгийг, 10 жилээр 13 нэр төрлийн 10779.5 мянган төгрөгийн хөрөнгийг элэгдүүлж байна.

1.2. *Эрсдэл*: Элэгдэл буруу тооцогдох, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. *Өгсөн зөвлөмж* Үндсэн хөрөнгийн ашиглах жил, элэгдлийг хувь хэмжээг зөв тооцож тайлан бүртгэлд тусгаж байх.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

*2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой*

*2.1. Илрүүлэлт*: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 20 нэр төрлийн 13162.8 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллагаагүй байна. Энэ нь “ТБ”, “ҮЗБ”, “ИББ” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*2.2. Эрсдэл*: Байгууллагын дансанд тэг үлдэгдэлтэй хөрөнгө их хэмжээгээр байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

*3.Бараа материалын данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Аж ахуйн материалын дансанд Кабинетын тохижилт 2991.8, кабинетын хэрэглэгдэхүүн 1795.1 мянган төгрөгийг бөөнөөр нь орлогод авсан материалын нэр төрөл тодорхойгүй байна.

*3.2. Эрсдэл*:

*3.3. Өгсөн зөвлөмж*: Бараа материалыг бүртгэлд тусгахдаа дансны ангилал, нэр төрлөөр нь бүртгэлд тусгах.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

4. Авлагын данстай холбоотой

*4.1 Илрүүлэлт:* Тайлант онд ХХОАТ-ын 30.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
4.2 Эрсдэл: Хууль зөрчигдөх,

4.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж өр авлага үүсгэхгүй ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР П.СОДНОМ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***.... 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| **2020** | | | САГ-2021/../СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **..........................** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| **ДҮН** | | | | | |